




## ТЭЭВЭР

### Төмөр замын тээвэр

Төмөр замын тээврээр 2020 оны эхний 2 сард 4.6 сая тонн ачаа тээвэрлэж, өмнөх

оны мөн үеэс 296.2 (6.8%) мянган тонноор өсжээ. Төмөр замын тээврээр тээсэн ачааны өсөлтөд экспортын ачаа 540.1 (35.1%) мянган тонн, импортын ачаа 21.2 (4.8%) мянган тонн, дамжин өнгөрөх ачаа 3.6 (0.7%) мянган тонноор тус тус өссөн нь нөлөөлсөн байна. Харин төмөр замын тээврээр тээсэн ачаа 2020 оны 2 дугаар сард 2.2 сая тонн болж, өмнөх сараас 246.9 (10.1%) мянган тонноор буурсан байна.

Зураг 1. Төмөр замын тээврээр тээсэн ачаа, мянган тонн, сараар




Төмөр замын тээврээр 2020 оны эхний 2 сард дотоодод болон гадаадад тээсэн нийт ачаанд уул уурхайн бүтээгдэхүүн 94.7 хувь, барилгын материал 1.5 хувь, хар төмөр 0.5 хувь, хөдөө аж ахуйн гаралтай бүтээгдэхүүн 0.8 хувь, хүнсний өргөн хэрэглээний бүтээгдэхүүн 0.8 хувь, мод модон материал 0.3 хувь, үйлдвэрийн тоног төхөөрөмж 0.03 хувь, бусад бүтээгдэхүүн 1.3 хувийг эзэлж байна.

Хүснэгт 1. Төмөр замаар тээсэн ачаа, бүтээгдэхүүний бүлгээр, дүнд эзлэх хувиар

Үзүүлэлт	2018 I-II	2019 I-II	2020 I-II *
<b>Бүгд</b>	<b>100.0</b>	<b>100.0</b>	<b>100.0</b>
Уул уурхайн бүтээгдэхүүн	93.4	91.9	94.7
Барилгын материал	1.8	2.5	1.5
Мод, модон материал	0.3	0.3	0.3
Хүнсний өргөн хэрэглээний бүтээгдэхүүн	0.9	0.8	0.8
ХАА-н гаралтай бүтээгдэхүүн	0.3	1.8	0.8
Хар төмөр (хаягдал, рельс г.м)	0.3	0.6	0.5
Бусад	3.0	2.1	1.3

Төмөр замын тээврээр (давхардсан тоо) 2020 оны эхний 2 сард 354.6 мянган хүн зорчиж, өмнөх оны мөн үеэс 25.4 (6.7%) мянган хүнээр буурсан байна. Төмөр замын тээврээр зорчигчид буурахад орон нутгийн зорчигчид 21.3 (5.8%) мянган хүнээр буурсан нь нөлөөлсөн байна. Төмөр замын тээврээр зорчигчид 2020 оны 2 дугаар сард 112.7 мянган хүн болж, өмнөх сараас 129.2 (53.4%) мянган хүнээр буурсан байна.

Зураг 2. Төмөр замын тээврээр зорчигчид, мянган хүн, сараар




Төмөр замын тээврийн орлого 2020 оны эхний 2 сард 115.1 тэрбум төгрөгт болж, өмнөх оны мөн үеэс 9.9 (9.4%) тэрбум төгрөгөөр өссөн байна. Энэхүү өсөлтөд дамжин өнгөрөх ачаа болон уул уурхайн бүтээгдэхүүн, тэр дундаа төмрийн хүдэр, жоншны тээвэрлэлтийн орлого голлон нөлөөлсөн байна. Харин төмөр замын тээврийн орлого 2020 оны 2 дугаар сард 53.0 тэрбум төгрөг болж, өмнөх сараас 9.0 (14.5%) тэрбум төгрөгөөр буурсан байна.

### АГААРЫН ТЭЭВЭР

Агаарын тээврээр 2020 оны эхний 2 сард 624.3 тонн ачаа тээвэрлэж, өмнөх оны мөн үеэс 183.7 (22.7%) тонноор буурсан байна. Мөн агаарын тээврээр тээсэн ачаа 2020 оны 2 дугаар сард 182.7 болж өмнөх сараас 259.0 (58.6%) тонноор буурсан байна. Агаарын тээврээр дотоодод тээсэн ачаа 2020 оны эхний 2 сард 11.4 (1.8%) тонн болж, өмнөх оны мөн үеэс 1.5 (10.9%) тонн, олон улсад тээсэн ачаа 613.0 (98.2%) тонн болж, өмнөх оны мөн үеэс 182.3 (22.9%) тонноор тус тус буурсан байна.

Зураг 3. Агаарын тээврээр тээсэн ачаа, тонн, сараар



Агаарын тээврээр зорчигчид 2020 оны эхний 2 сард давхардсан тоогоор 178.0 мянган хүн болж, өмнөх оны мөн үеэс 19.9 (10.1%) мянган хүнээр буурсан байна. Мөн агаарын тээврээр зорчигчид 2020 оны 2 дугаар сард 65.2 мянган хүн болж, өмнөх сараас 47.6 (42.2%) мянган хүнээр буурсан байна.

Агаарын тээврээр орон нутагт зорчигчид 2020 оны эхний 2 сард 54.1 (30.4%) мянган хүн болж, өмнөх оны мөн үеэс 9.2 (14.5%) мянган хүнээр буурсан байна. Энэхүү бууралтад Оюутолгой чиглэлийн зорчигчид 10.8 хувь, Чойбалсан чиглэлийн зорчигчид 70.7 хувь, Улаангом чиглэлийн зорчигчид 51.8 хувиар тус тус буурсан нь голлон нөлөөлсөн байна.

Агаарын тээврээр олон улсад зорчигчид 2020 оны эхний 2 сард 123.9 (69.6%) мянган хүн болж, өмнөх оны мөн үеэс 10.8 (8.0%) мянган хүнээр буурсан байна. Энэхүү бууралтад Улаанбаатар-Бээжин чиглэлийн зорчигчид 48.9 хувь, Улаанбаатар-Эрхүү чиглэлийн зорчигчид 33.2 хувь, Улаанбаатар-Бангкок чиглэлийн зорчигчид 27.9 хувь, Улаанбаатар-Хайлаар чиглэлийн зорчигчид 24.2 хувь, Улаанбаатар-Гонконг чиглэлийн зорчигчид 22.9 хувиар буурсан нь голлон нөлөөлсөн байна.

Агаарын тээврийн салбарын (үндэсний тээвэрлэгч) орлого 2020 оны эхний 2 сард 48.0 тэрбум төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 13.3 (21.7%) тэрбум төгрөгөөр буурсан байна. Түүнчлэн агаарын тээврийн салбарын орлого 2020 оны 2 дугаар сард 16.9 тэрбум төгрөг болж, өмнөх сараас 14.2 (45.7%) тэрбум төгрөгөөр буурсан байна.

Зураг 3. Агаарын тээврээр зорчигчид, мянган хүн, сараар

